



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018.03.25 № 06.125
танай _____ -ны № _____ -т

Г _____ Т
Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.3-д заасны дагуу Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


Үүрэг, хариуцлага

Дэлгэрхаан сумын ТЕЗ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасны дагуу Тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

0600644

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

62

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ДЭЛГЭРХААН СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Аудитын код: ХЭА-/2018/5/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу.

Цахим хуудас: Khentii@audit.gov.mn

Хэнтий аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер Д.Оюунтуяа
Утас: 70562147

Аудитор Ц.Хатанболд
Утас: 70562147

Чингис хот

АГУУЛГА

2.1 ОРШИЛ.....	2
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	2
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	3
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	3
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	4
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	4
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	4
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	5
2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	5
2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	5
2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	5
2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	5
2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	5
2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.12 Шилэн дансны мэдээлэл	6
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	8
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	8
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	8
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
3.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8

2. Аудитын тайлан

2.1 ОРШИЛ

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Дэлгэрхаан сумын Засаг дарга О.Анхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 6 төсвийн байгууллага, 4 орон нутгийн тусгай сан, төрийн сан 1, эмийн эргэлтийн сан 1 зэрэг нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэсэн байна.

Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд “Ай Жэй Эй Эйч аудит” ХХК зөрчилгүй санал дүгнэлт, Цэцэрлэг, Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар зөрчилгүй санал, дүгнэлт гаргасан байна.

Аудитаар:

1. Засаг даргын тамгын газарт цалингийн шатлал ахиулсан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 зөрчилд зөвлөмж өгсөн байна.
2. Хүүхдийн цэцэрлэгт газарт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 зөрчилд зөвлөмж өгсөн байна.
3. Ерөнхий боловсролын сургуульд харилцагч байгууллага хувь хүмүүстэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй 2 зөрчилд зөвлөмж өгсөн байна.
4. Эрүүл мэндийн төвд 1,5 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн байна

/Дэлгэрэнгүй мэдээллийг тухайн байгууллагын аудитын тайлангаас харна уу/

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Соёлын төв, ОНХС, СХС, ЭЭС-ийн 2017 оны санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт,

нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 3 дүгээр сарын 20-ноос 2018 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Дэлгэрхаан сумын ТЕЗ-д хүргүүлэхээр төлөвлөн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Хатанболд хариуцаж хэрэгжүүлэв.

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дэлгэрхаан сумын Засаг даргын 2018 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 21 тоот албан бичгээр Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Шилэн дансны тухай, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дэлгэрхаан сумын Засаг дарга “Санхүү, төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, гүйцэтгэлийг хангах, нөөцийг оновчтой ашиглаж, хариуцлагын тогтолцоог уялдуулах, төрийн сангийн шуурхай үйлчилгээг бий болгож төсөв санхүүгийн таатай орчин бүрдүүлэх замаар

санхүү, эдийн засгийн үр ашигтай удирдлагаар хангахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Дэлгэрхаан сумын ТЕЗ нь дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл ойлголтод үндэслэн эрсдлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн аудитын 6 эрсдэл тодорхойлон, тэдгээрийг ТБ-СТА-Б-2.2 маягтад нэгтгэж баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийт хөрөнгө болон цэвэр өмчийн дүн өндөр байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1805,1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 18,0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 6 эрсдэлтэй асуудалд 6 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй болно. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитын хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудад дараах алдаа, зөрчил илэрсэн.

1. Эмийн эргэлтийн санд 1,8 сая төгрөгийн авлага, 0,6 сая төгрөгийн өглөгт тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэгдсэн тайланд хийсэн аудитаар төлбөрийн акт тогтоосон алдаа зөрчил илрээгүй.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэгдсэн тайланд хийсэн аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэгдсэн тайланд хийсэн аудитаар сахилгын шийтгэл ногдуулах зөрчилтэй асуудал гараагүй.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал гараагүй.

2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дэлгэрхаан сумын ТЭЗ-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1379,3 сая төгрөгийн, хөрөнгийн зардалд 65,9 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1379,4	1344,9	-2,5%	34,5
1.1	Урсгал зардал	1282,8	1271,2	-0,9%	11,6
1.2	Хөрөнгийн зардал	65,9	61,6	-6,5%	4,3
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	30,6	12,0	-39%	18,2
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1379,4	1310,9	-4,9%	68,5
2.1	Улсын төсвөөс санхүүжих	986,2	979,6	-0,6%	6,6
2.2	НД-ын сангийн төсвөөс санхүүжих	-	-	-	-
2.3	Орон нутгийн төсвөөс санхүүжих	279,1	274,0	-1,8%	5,1
2.4	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	80,8	45,4	-43,8%	35,4
2.5	Бусад эх үүсвэр	24,7	2,6	89%	22,1

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд урсгал зардал 11.6 сая төгрөг буюу 0,9 хувиар хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсвийн гүйцэтгэлд анхаарал татахуйц их хэмжээний хэлбэлзэл алга байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Дэлгэрхаан сумын ТЭЗ-ийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг "shilendans.gov.mn" цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Аймаг дахь Төрийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны эхний 10 сарын байдлаар нийцлийн аудит хийхэд зөрчил илрээгүй болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Дэлгэрхаан сумын ТЭЗ-ийн өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл


Бид Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР


Огноо: 2018.3.28

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

Огноо:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



Ц.ХАТАНБОЛД

Огноо:

3. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 3.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**



Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Эмийн эргэлтийн сангийн талаар3

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Илрүүлэлт:

1. Эмийн эргэлтийн санд 1,8 сая төгрөгийн авлага, 0,6 сая төгрөгийн өглөгт тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн нь үнэн зөв байдал, оршин байгаа, толилуулга ба илчлэл тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Зөвлөмж:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

Эрсдэл:


НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх
Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ч.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Ц.ХАТАНБОЛД

Огноо: 2018-03-22